## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
## ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

**Манхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Аудитын код: ХОА-2022/07/НА-СТА-ТТЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Ховд хот<br>2023 он | Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn<br>Аудитор: Erdenetsetsegd@audit.gov.mn<br>Утас:<br>Цахим хаяг: |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1.**ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**......3
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**......5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан (мянган төгрөг)......5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (мянган төгрөг......6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)......9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)......12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)......13
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)......15
3. **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**......16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа......16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал......17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд......17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв......20
4. **АУДИТЫН ТАЙЛАН**......22
4.1 Ерөнхий зүйл......22
4.2 Материаллаг байдал......22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт......23
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт......23
5. **АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**......24
6. **АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**......27

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ӨХЗ | Өмч хамгаалах зөвлөл |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуун тооцоот үйлдвэрийн газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ГХУСЗЗ | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл |
| ХХС | Хоршоо хөгжүүлэх сан |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.03.25 № 2/119
танай ____________-ны №____________-т

МАНХАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.ЛХАГВАСҮРЭН
ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Манхан сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Манхан сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын зардлын зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, жолоочийн тооцоо бодож замын хуудас баталгаажуулаагүй, төсвөөс үр ашиггүй тэвчиж болох зардлуудад хөрөнгө гаргасан зэрэг 152.5 сая төгрөгийн зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, “Тохиолдсон байх”, “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Нийт орлого 417.3 сая төгрөг орж 44.6 сая төгрөгөөр тасарч биелсэн байна.Малын хөлийн татвар 30.6 сая, газрын төлбөр 0.3 сая, ан амьтан нөөц ашигласны төлбөр 51.4 сая төгрөгөөр тасарч татварын бус орлого 19.0 сая, цалин хөлсний орлого 54.1 сая, хүн амын орлогын албан татвар 17.0 сая төгрөгөөр биелсэн байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ нь Цэцэрлэгийн хуучин байрны засвар 80.0 сая, Соёлын төвийн дээвэр, гадна пасадны засвар 87.4 сая, Гэр хорооллын гэрэлтүүлгийн ажилд 25.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хэрэгжүүлсэн нь иргэдийн эрх ашигт нийцсэн үр дүнтэй ажил болсон байна.

021020180

**Бусад асуудлын хэсэг**

Өмнөх онуудад төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн санхүүгийн тайлангийн тогтмол зардлаас бусад үзүүлэлтүүд системийн дээд байгууллагын тайланд нэгтгэгдэх бодлогын өөрчлөлт бий болсонтой холбоотойгоор эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд нөлөөлөл бүхий өөрчлөлтүүд орсон байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 766,665.3 | 397,866.6 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 182,745.2 | 201,069.3 |
| 33 | АВЛАГА | 238,359.0 | 136,576.3 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 341,071.1 | 40,285.0 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 4,490.0 | 19,936.0 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 8,188,284.8 | 4,378,891.3 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 8,188,284.8 | 4,378,891.3 |
| 39200 | Биет хөрөнгө | 7,992,103.2 | 4,286,176.4 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 196,181.6 | 92,714.9 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 8,954,950.1 | 4,776,757.9 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 5,813.0 | 12,409.5 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 5,813.0 | 12,409.5 |
| 41300 | Өглөг | 5,813.0 | 12,409.5 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 8,949,137.1 | 4,764,348.4 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 8,949,137.1 | 4,764,348.4 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 3,468,482.9 | 974,241.4 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 3,468,482.9 | 974,241.4 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 3,287,655.3 | 2,786,099.0 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,192,999.0 | 1,004,008.0 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 8,954,950.1 | 4,776,757.9 |

### 2.2 **Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан**

/мянган.төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2021оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 4,613,356.80 | 1,754,002.20 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 83,469.20 | 358,191.00 |
| 110 | Орлогын албан татвар | 65,091.80 | 242,142.40 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 65,091.80 | 242,142.40 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 2,778.00 | 57,422.90 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 15,599.50 | 58,625.70 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 248,625.50 | 240,897.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 248,625.50 | 240,897.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,281,262.10 | 1,154,914.20 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 4,789,596.40 | 1,881,331.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,789,596.40 | 1,881,331.40 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,604,340.40 | 1,821,424.70 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,984,112.70 | 450,800.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 260,532.00 | 55,180.50 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 360,132.00 | 483,489.70 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 230,833.50 | 469,842.20 |
| 2105 | Нормативт зардал | 172,890.50 | 335.30 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,867.90 | 8,478.50 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 5,730.70 | 4,991.20 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 22,318.70 | 9,508.20 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 560,922.30 | 338,799.20 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,185,256.00 | 59,906.70 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | (176,239.60) | (127,329.30) |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 8,727.60 | 3,998,678.30 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | (184,967.20) | (4,126,007.60) |

2.3 **Аудит хийсэн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан**

/мянган.төгрөгөөр/

| **Код:** | **Тайлангийн үзүүлэлт** | **2021оны 12-р сарын 31** | **2022 оны 12-р сарын 31** |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 4,537,537.60 | 1,630,348.60 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 83,469.20 | 358,191.00 |
| 110 | Орлогын албан татвар | 65,091.80 | 242,142.40 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 65,091.80 | 242,142.40 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 2,778.00 | 57,422.90 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 15,599.50 | 58,625.70 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 3,386.60 | 10,271.60 |
| 1181 | Газрын төлбөр | 1,742.90 | 3,590.20 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 10,470.00 | 44,763.80 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 194,135.50 | 107,043.40 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 194,135.50 | 107,043.40 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 4,259,932.90 | 1,165,114.20 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,264,453.30 | 1,179,241.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,264,453.30 | 1,179,241.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,063,380.30 | 1,116,609.40 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,983,631.30 | 451,939.90 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 260,082.80 | 54,524.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 365,780.00 | 483,994.70 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 70,796.00 | 25,711.30 |
| 2105 | Нормативт зардал | 192,415.60 | 485.3 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,192.40 | 9,155.90 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,230.70 | 3,491.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,045.50 | 11,418.20 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 151,206.00 | 75,889.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,201,073.00 | 62,631.70 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 273,084.30 | 451,107.60 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 195,438.60 | 432,683.50 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 195,438.60 | 432,683.50 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 195,438.60 | 432,683.50 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -195,438.60 | -432,683.50 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | -33 | -100 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 33 | 100 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 77,612.70 | 18,324.10 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 105,132.50 | 182,745.20 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 182,745.20 | 201,069.30 |

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

/мянган.төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| 1 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 9,118,142.3 | 9,118,142.3 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 3,093.1 | 3,093.1 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 9,121,235.4 | 9,121,235.4 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | (3,093.1) | (3,093.1) |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 15,962.0 | 15,962.0 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | (184,967.2) | (184,967.2) |
| 10 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 8,949,137.1 | 8,949,137.1 |
| 11 | 2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 8,949,137.1 | 8,949,137.1 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (123,084.9) | (123,084.9) |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 8,826,052.2 | 8,826,052.2 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | (4,126,007.6) | (4,126,007.6) |
| 20 | 2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 4,764,348.4 | 4,764,348.4 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

/мянган.төгрөгөөр/

| | *Үзүүлэлт* | *Тайлант оны* |
|---|---|---|

| Эдийн засгийн ангилал | | *Батлагдсан төлөвлөгөө* | **Гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,790,177,200.00 | 1,575,531,572.48 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,790,177,200.00 | 1,142,748,065.48 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,730,270,500.00 | 1,082,841,365.48 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 453,693,300.00 | 451,939,956.39 |
| 210101 | Үндсэн цалин | 319,520,600.00 | 307,981,313.22 |
| 210102 | Нэмэгдэл | 72,120,100.00 | 71,899,091.41 |
| 210104 | Урамшуулал | 9,449,600.00 | 23,074,223.73 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 52,603,000.00 | 48,985,328.03 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 55,956,700.00 | 54,523,947.75 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,130,400.00 | 37,633,387.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,303,000.00 | 4,116,812.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,653,700.00 | 3,479,805.67 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 897,500.00 | 709,300.93 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,972,100.00 | 8,584,641.20 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 483,996,800.00 | 483,994,679.20 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 24,438,800.00 | 24,438,479.20 |
| 210302 | Түлш, халаалт | 455,177,800.00 | 455,466,600.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,380,200.00 | 4,089,600.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 25,713,800.00 | 25,711,257.14 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,682,600.00 | 2,882,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,598,800.00 | 18,598,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,232,400.00 | 4,029,857.14 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 200,000.00 | 200,000.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 485,300.00 | 485,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 485,300.00 | 485,300.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,155,900.00 | 9,155,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 167,000.00 | 167,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,988,900.00 | 8,988,900.00 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 3,495,200.00 | 3,491,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | 3,495,200.00 | 3,491,200.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,803,800.00 | 10,191,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,515,800.00 | 9,515,100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 420,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 145,000.00 | 128,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 145,000.00 | |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 30,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 425,000.00 | 425,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 123,000.00 | 123,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 43,348,200.00 | 43,348,025.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,748,200.00 | 27,748,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 15,600,000.00 | 15,599,825.00 |
| 2132 | **Бусад урсгал шилжүүлэг** | 59,906,700.00 | 59,906,700.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 35,749,700.00 | 35,749,700.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 24,157,000.00 | 24,157,000.00 |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 503,621,500.00 | 432,683,507.00 |
| 2200 | **Дотоод эх үүсвэрээр** | 503,621,500.00 | 432,683,507.00 |
| 220001 | Барилга байгууламж | 165,600,000.00 | 165,226,916.00 |
| 221001 | Их засвар | 262,800,000.00 | 244,456,591.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 75,221,500.00 | 23,000,000.00 |
| 23 | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 140,000,000.00 | 100,000.00 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 140,000,000.00 | 100,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,790,177,200.00 | 1,651,920,901.48 |
| 1320 | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,643,459,600.00 | 1,604,077,565.48 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,256,531,500.00 | 1,217,149,465.48 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 386,928,100.00 | 386,928,100.00 |
| 120004 | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 146,717,600.00 | 47,843,336.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 605,000.00 | 5,625,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 40,292,100.00 | 42,218,336.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 105,820,500.00 | |
| 4 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 105,820,647.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 182,209,976.50 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан

/мянган.төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 39,620,749.45 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 39,620,749.45 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 39,620,749.45 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | - |
| 210402 | Тээвэр, шатахуун | - |
| 2105 | **Нормативт зардал** | - |
| 210502 | Хоол, хүнс | - |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,227,000.00 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 38,393,749.45 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,540,994.00 |
| 210902 | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг | 5,852,755.45 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 39,620,749.45 |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 39,620,749.45 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 39,620,749.45 |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)**-(I) | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

# 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 **Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Манхан сумын Засаг дарга нь Монгол улсын Үндсэн хууль болон УИХ, Засгийн газраас гарч буй хууль тогтоомжид нийцүүлэн “Орон нутгийн хөгжил дэвшилд манлайлагч байж мэдлэг чадварт суурилсан нутгийн захиргааны мэргэшсэн байгууллага байх” эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон дараах зорилтыг тавин ажилласан байна.Үүнд:

- ✓ Хууль тогтоомж, хөгжлийн бодлого, стратеги зорилт, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохин байгуулж хяналт тавих
- ✓ Баг байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулж, мэргэшил арга зүйн удирдлагаар хангах
- ✓ Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохин байгуулах
- ✓ Тамгын газрын үйл ажиллагааг удирдан зохин байгуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тайлагнах, хяналт тавих
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг
- ✓ Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, цахим систем нэвтрүүлж, иргэдийн цаг хугацаа зардлыг хэмнэх
- ✓ Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ,

- ✓ Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ

## 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд нь Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд 4 удаа, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1 удаа, Төсвийн тухай хуульд 6 удаа, Шилэн дансны тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт орж Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдан мөрдөгдөж эхэлсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 15-р тогтоолоор байгуулагдсан сумын өмч хамгаалах байнгын зөвлөл тус сумын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж төсвийн хөрөнгөөр болон хандив тусламжаар ирсэн хөрөнгөд хяналт тавин ИТХ-ын хуралдаанаар тогтоол гаргуулан өмч хөрөнгийг бүртгэлд тусгуулж, актлах хөрөнгийг шийдвэрийн дагуу устгах ажлыг хариуцан ажиллаж жилийн ажлыг 87.6 хувьтай дүгнүүлсэн байна.

Манхан сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 **Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Манхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

## 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Манхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4178,2 сая төгрөгөөр буюу 50.1 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Тайлангийн үзүүлэлтүүд | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 182,745.2 | 201,069.3 | (18,324.1) | 1.1 |
| Авлага | 238,359.0 | 136,576.3 | 101,782.7 | 0.6 |
| Бараа материал | 345,561.1 | 60,221.0 | 285,340.1 | 0.2 |
| Үндсэн хөрөнгө | 8,188,284.8 | 4,378,891.3 | 3,809,393.5 | 0.5 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | 8,954,950.1 | 4,776,757.9 | 4,178,192.2 | 0.5 |
| Богино хугацаат өр төлбөр | 5,813.0 | 12,409.5 | (6,596.5) | 2.1 |
| **Цэвэр өмчийн дүн** | 8,949,137.1 | 4,764,348.4 | 4,184,788.7 | 0.5 |
| Засгийн газрын хувь орлоцоо | 8,949,137.1 | 4,764,348.4 | 4,184,788.7 | 0.5 |
| Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 3,468,482.9 | 974,241.4 | 2,494,241.5 | 0.3 |
| Хуримтлагдсан үр дүн | 3,287,655.3 | 2,786,099.0 | 501,556.3 | 0.8 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,192,999.0 | 1,004,008.0 | 1,188,991.0 | 0.5 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 8,954,950.1 | 4,776,757.9 | 4,178,192.2 | 0.5 |

*Эх сурвалж: Манхан сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Дээрх хүснэгтээс харахад, *санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлттэй мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө цэвэр өмч хөрөнгийн дансууд байна.*

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 182.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 201.0 сая төгрөг болж 18.3 сая төгрөгөөр буюу 1.1 хувиар өссөн байна. ОНХС-ийн төлөвлөсөн ажлууд он дамжин хэрэгжиж байгаатай холбогдон олгогдоогүй санхүүжилтийн үлдэгдлээр өссөн байна.

### 3.4.**2 Авлага**

Авлага дансны эцсийн үлдэгдэл 136.6 сая төгрөг болж, өмнөх оноос 101.8 сая төгрөгөөр *буурсан* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Эхний үлдэгдэл** | **Эцсийн үлдэгдэл** | **Өсөлт (+), Бууралт (-)** |
|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 399.6 | 1,065.6 | 666.0 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 37,422.5 | - | (37,422.5) |
| Татаас санхүүжилтийн авлага | 2,792.2 | - | (2,792.2) |
| Зээлийн хүүгийн авлага | 5,560.4 | 5,560.4 | - |
| Байгууллагаас авах авлага | 20,663.2 | 13,050.1 | (7,613.1) |
| Хувь хүмүүсээс авах авлага | 42,486.8 | 29,984.3 | (12,502.5) |
| **Дүн** | 109,324.7 | 49,660.4 | (59,664.3) |
| Тусгай зориулалтын сан | 129,034.3 | 86,915.9 | (42,118.4) |
| **Дүн** | 129,034.3 | 86,915.9 | (42,118.4) |
| **АВЛАГЫН НИЙТ ДҮН** | 238,359.0 | 136,576.3 | (101,782.7) |

*Эх сурвалж: Манхан сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Ажилчидтай холбоотой авлага 0.6 сая төгрөгөөр өссөн нь, урьдчилгаа цалингийн авлагатай холбоотойгоор өссөн, байгууллагаас авах авлага 3.7 сая, хүмүүсээс авах авлага 12.5 сая, зээлийн хүүгийн авлага 5.5 сая төгрөгөөр буурсантай холбоотой өөрчлөгдсөн байна.

### 3.4.3 Урьдчилгаа

Урьдчилж гарсан зардлын дансаар мөнгөн орлого зарлага хийгдээгүй байна.

### 3.4.4 **Бараа материал**

Бараа материалын дансны үлдэгдэл 60.2 сая төгрөг болж 285.3 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Тайлангийн үзүүлэлтүүд | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|
| Түүхий эд материал | 89,995.1 | - | 89,995.1 | 0.0 |
| Тусгай зориулалттай материал | 30,296.5 | - | 30,296.5 | 0.0 |
| Эм боох материал | 59,698.6 | - | 59,698.6 | 0.0 |
| Бэлэн бүтээгдэхүүн | - | - | - | 0.0 |
| Хангамжийн материал | 251,076.0 | 40,285.0 | 210,791.0 | 16% |
| Бичиг хэргийн материал | 1,365.6 | 150.0 | 1,215.6 | 0.1 |
| Аж ахуйн материал | 51,842.7 | 26,625.1 | 25,217.6 | 0.5 |
| сэлбэг хэрэгсэл | 703.0 | - | 703.0 | 0.0 |
| Түлш шатах тослох материал | 4,033.0 | - | 4,033.0 | 0.0 |
| Барилгын засварын материал | 258.0 | - | 258.0 | 0.0 |
| Хүнсний материал | 33,014.2 | - | 33,014.2 | 0.0 |
| Бусад хангамжийн материал | 154,652.5 | 8,542.9 | 146,109.6 | 0.1 |
| Мал амьтад | 5,207.0 | 4,967.0 | 240.0 | 1.0 |
| Нөөцийн бараа | 4,490.0 | 19,936.0 | (15,446.0) | 1.0 |
| Нийт бараа материал | 345,561.1 | 60,221.0 | 285,340.1 | 0.2 |

*Эх сурвалж: Манхан сумын ТТЗ-ын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 94.2 сая төгрөгийн худалдан авалт хийж 16.6 сая төгрөгийн үнэ төлбөргүй материал орлого авч 77.9 сая төгрөгийн материал зарцуулж 301.6 сая төгрөгийн материал төсөвт байгууллагуудад шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөлт орсон байна.

### 3.4.5 **Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 11128.1 сая төгрөг байсан бол оны эцэст 6342.6 сая төгрөг болж 4785.5 сая төгрөгөөр буурсан нь Засаг даргын тамгын газрын балансад бүртгэлтэй улсын төсвийн байгууллагуудын 4735.5 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, 50.0 сая төгрөгийн хөрөнгийн данс хооронд шилжүүлсэн. ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 6 ажлын өртөг 213.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын хөрөнгө орлогод авч, 276.3 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой буурсан байна.

### 3.4.6 **Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 5.8 сая, эцсийн үлдэгдэл 12.4 сая төгрөг болж 6.6 сая төгрөгөөр өссөн нь байгууллагад өгөх хөрөнгө оруулалтын ажлын дутуу санхүүжилттэй холбоотой өглөг байна.

3.4.7 **Цэвэр хөрөнгө, өмч**

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 8949.1 сая төгрөг байснаас оны эцэст 4764.3 сая төгрөг болж 4174.3 сая төгрөгөөр буурсан нь Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн баланс шилжсэнтэй холбоотой байна.

3.5 **Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.**1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1790.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1790.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Манхан сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 04 өдрийн 5/07 тоот тогтоолоор 1930.4 сая төгрөгөөр анх баталж ирснийг сум ИТХ-ын 2021 оны 12 сарын 17-ны 4/03 тогтоолоор 1930.4 сая төгрөгөөр баталсан. Өмнө оны болон тайлант оны давсан орлоготой холбоотойгоор аймаг 2022 онд 1 удаа тодотгол хийн 2022 оны 06 дугаар сарын 10-ны 4/05 тоот тогтоолоор нийт 1790.2 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 6/05 тоот тогтоолоор 1790.2 сая төгрөгөөр тодотгож баталжээ.

3.5.**2 Төсвийн гүйцэтгэл**

